



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/498

Булган сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн нутаг дэвсгэрт агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
Гишүүд: Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын Улсын байцаагч Байгаль орчин, аялал жуулчлалын газрын агаарын бохирдол, хог хаягдал, химийн бодис хариуцсан мэргэжилтэн Авто Тээврийн Үндэсний төвийн Аж ахуйн тооцоот ТӨҮГ-ын Булган аймаг дахь газрын ерөнхий инженер “Булган мээж” ОНӨХХК-ийн ерөнхий инженер “Энержи плас” ХХК-ийн ерөнхий инженер
Нарийн бичгийн дарга: Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн ерөнхий инженер

2. Сумын агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын дүнг аймгийн хэмжээнд нэгтгэж, агаарын бохирдлын ялгарлын хэмжээ тооцох ажлыг Ус цаг уур, орчны шинжилгээний төвд үүрэг болгосугай.

4. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион

байгуулж, нэгдсэн дүнг тус оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын удирдлагын багийн хуралд танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/506 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.



ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ